

23



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2020 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 01/04

Бодь

┌ **Сумын Засаг даргыг томилуулахаар** ┐
уламжлах тухай

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 8 дахь удаагийн сонгуулийн үр дүнгээр байгуулагдаж байгаа тус сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар хуралдаанаар сумын Засаг даргыг сонгож, томилуулахаар аймгийн Засаг даргад уламжлах тухай хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн "г", 26.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн 57 хувийн саналаар Равжаагийн Батжаргалыг сумын Засаг даргаар томилуулахаар аймгийн Засаг даргад уламжилсугай.
2. Тогтоолыг холбогдох материалын хамт аймгийн Засаг даргад өргөн мэдүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /М.Ган-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.

ДАРГА  ДАМАР-АМГАЛАН



1617073